



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 496

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч иргэн Р.Туяацэцэгийн 208,996,000 /хоёр зуун найман сая есөн зуун ерэн зургаан мянга/, У.Сийлэнгийн 119,504,000 /нэг зуун арван есөн сая таван зуун дөрвөн мянга/, П.Ганзоригийн 21,500,000 /хорин нэгэн сая таван зуун мянга/, нийт 350,000,000 /гурван зуун тавин сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Р.Туяацэцэг	1,367,460,000.0	208,996,000.0	1,576,456,000.0	57,33
2	У.Сийлэн	832,540,000.0	119,504,000.0	952,044,000.0	34,62
3	П.Ганзориг	200,000,000.0	21,500,000.0	221,500,000.0	8,05
	Нийт	2,400,000,000.0	350,000,000.0	2,750,000,000.0	100,00

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000140